МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,
Цахим шуудан: info@energy.gov.mn

2026.05.21 № 4/2059

танай ____________ -ны № ______________ -т

САЛБАРЫН ТӨРИЙН ӨМЧИТ
КОМПАНИУДЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ НАРТ

Тус яамны Жендэрийн салбар зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар хүргүүлж байна.

Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллаж, тайланг 2026 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг мэдэгдье.

Хавсралт 5 хуудастай.

Эрчим хүчний яам
Төрийн захиргааны удирдлагын газар
Газрын дарга
П.Билгүүн
2026.05.21 11:33

БАТЛАВ: ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БӨГӨӨД САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ЕРЭН-ӨЛЗИЙ

**ЖЕНДЭРИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| № | Зорилго, зорилт, үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Төсөв | Хэмжих нэгж | Суурь түвшин | Зорилтот Түвшин | Хэрэгжүүлэх байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Үндсэн | Хамтрагч |
| 0 | 1 | 2 | | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 1. САЛБАРЫН УДИРДЛАГА, АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДАД ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН МЭДЛЭГ, ЧАДВАР, ХАНДЛАГЫГ ТӨЛӨВШҮҮЛЖ, ЖЕНДЭРИЙН ХЭВШМЭЛ ҮЗЛИЙГ ӨӨРЧЛӨХ ЦОГЦ ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилт 1.1. Салбарын удирдлага, ажилтан, албан хаагчдад жендэрийн эрх тэгш байдлын мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлж, жендэрийн хэвшмэл үзлийг өөрчлөх ажиллагаа хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| **1.1.2 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд**<br>Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчид зориулсан жендэрийн сургалтын хөтөлбөр, модуль боловсруулж нэвтрүүлнэ. | | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1**<br>Улаанбаатар хотын үйлдвэр компаниудын Удирдах ажилтнууд болон албан хаагчдад жендэрийн сургалт зохион байгуулна. | Сургалтад хамрагдсан байгууллага | - | тоо | 3 | 5 | ЭХЯ | “ДЦС”-3 ТӨХК<br>“ДЦС”-2 ТӨХК<br>“УБЦТС” ТӨХК<br>“УБДС” ТӨХК<br>“ЭХҮТ” ТӨХХК |
| **1.1.3 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд**<br>Салбарын төрийн ба хувийн хэвшлийн ААНБ-ын удирдах албан тушаалтан, ажилтан, албан хаагчид зориулсан сургалт явуулах үндэсний болон орон нутгийн сургагч багш бэлтгэнэ. | | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1**<br>Салбарын жендэрийн сургагч багш нарыг Жендэрийн үндэсний хорооны цахим платормд бүртгүүлэх, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллана. | Салбарын сургагч багш | - | тоо | 0 | 8 | ЖҮХ | ЭХЯ |
| **Стратеги төлөвлөгөөний зорилт 1.2. Салбарын жендэрийн эрх тэгш байдлыг хангах бүтэц тогтолцоог бэхжүүлж, хууль тогтоомж, бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлнэ.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.2.1 үйл ажиллагаар хэрэгжүүлэх хүрээнд**<br>Салбарын жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг ААНБ, ИНБ-ын төлөөллөөр өргөтгөн, гишүүдийн ажил үүргийн хуваарийг гаргаж, удирдамжаар хангах, яамны бодлого төлөвлөлтийн нэгжид жендэрийн орон тооны мэргэжилтэн, төрийн өмчит болон хувийн хэвшлийн ААНБ-д жендэрийн асуудал хариуцсан ажилтан ажиллуулна. | | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 1**<br>Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг ААНБ, ИНБ-ын төлөөллөөр өргөтгөн шинэчлэн байгуулна. | - | - | тоо | 1 | 1 | ЭХЯ | - |
| 2. | **Арга хэмжээ 2**<br>Салбарын төрийн өмчит компаниудад жендэрийн асуудал хариуцсан ажилтанг хавсран ажиллуулах ажилд бодлогын дэмжлэг үзүүлнэ. | - | - | тоо | 1 | 1 | ЭХЯ | - |
| 3. | **Арга хэмжээ 3**<br>Салбарын жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг жендэрийн анхан шатны сургалтад хамруулна. | Сургалтад хамрагдсан албан тушаалтан | - | тоо | 1 | 1 | ЖҮХ | ЭХЯ |
| **1.2.5 үйл ажиллагаар хэрэгжүүлэх хүрээнд**<br>Салбарын хүйсээр ангилсан мэдээлэл, жендэрийн статистикийг өргөжүүлэн, судалгаа, бусад мэдлэгийн бүтээгдэхүүний цахим сан байгуулж, ашиглалтыг хангана. | | | | | | | | |
| 1. | Эрчим хүчний салбарын статистик үзүүлэлтээр мэдлэгийн бүтээгдэхүүний цахим сан байгуулах ажлыг зохион байгуулна. | Цахим сан байгуулах | - | тоо | - | 1 | Эрчим хүчний зохицуулах хороо | - |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 2. САЛБАРЫН ААНБ-ЫН УДИРДАХ ТҮВШИНД ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ, АЖИЛ ЭРХЛЭЛТ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНД ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ОРЧИН НӨХЦӨЛ БҮРДҮҮЛЭХ БОДЛОГО, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилт 2.1. Салбарын ААНБ-ын шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангана.** | | | | | | | | |
| **2.1.3 үйл ажиллагаар хэрэгжүүлэх хүрээнд**<br>Сайд, ТНБД-ын шийдвэрээр байгуулсан болон үндэсний хэмжээний хороо зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагын бүрэлдэхүүнд хүйсийн 40:60 харьцааг хангана. | | | | | | | | |
| 1. | **Хэрэгжүүлэх ажил 1**<br>Сайд, ТНБД-ын шийдвэрээр байгуулсан болон үндэсний хэмжээний хороо зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагын бүрэлдэхүүнд хүйсийн 40:60 харьцаагаар хангах | | - | тоо | - | 1 | ЭХЯ | - |

<table>
<tr><td></td><td>талаар удирдлагууд болон холбогдох албаны хүмүүсийг мэдээллээр хангаж, санал өгнө.</td><td>Мэдээлэл өгсөн байдал</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="9">2.1.7 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд<br>ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүнээр ажиллах эмэгтэйчүүдийн чадавхыг дээшлүүлж, оролцоог нэмэгдүүлнэ.</td></tr>
<tr><td>1.</td><td>Хэрэгжүүлэх ажил 1<br>Төрийн өмчит хувьцаат компаниудын ТУЗ-ийн гишүүн, хараат бус гишүүдын бүрэлдэхүүнд хүйсийн 40:60 харьцааг хангах талаар удирдлагууд болон холбогдох албаны хүмүүсийг мэдээллээр хангаж, санал өгнө.</td><td>Мэдээлэл өгсөн байдал</td><td>-</td><td>тоо</td><td>-</td><td>1</td><td>ЭХЯ</td><td>-</td></tr>
<tr><td colspan="9">Стратеги төлөвлөгөөний зорилт 2.2. Салбарын төрийн болон хувийн хэвшлийн бүх ААНБ-ын ажилтанд жендэрийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн, ажил-ар гэрийн амьдралын тэнцвэр хангасан орчин нөхцөл бүрдүүлэх, эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш үр шим хүртэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.</td></tr>
<tr><td colspan="9">2.2.3 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд<br>Салбарын түвшинд ажлын байрны эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ, эрүүл мэндийн үзлэгийг жендэрийн мэдрэмжтэй явуулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.</td></tr>
<tr><td>1.</td><td>Хэрэгжүүлэх ажил 1<br>Эрүүл мэндийн үзлэгийг жендэрийн мэдрэмжтэй явуулах ажлыг зохион байгуулна.</td><td>Хэрэгжүүлсэн байгууллага</td><td>-</td><td>тоо</td><td>-</td><td>10</td><td>Салбарын байгууллагууд</td><td>ЭХЯ</td></tr>
<tr><td colspan="9">2.2.4 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд<br>Эрэгтэй ажилтны дундаж наслалтын судалгааг гаргаж, нөлөөллийн хүчин зүйлсийг илрүүлж, тэдэнд эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх (эрүүл хоол хүнс хэрэглэх, хорт зуршил, стрессийг арилгах) зөвлөмж боловсруулж, хэрэгжүүлнэ.</td></tr>
<tr><td>1.</td><td>Хэрэгжүүлэх ажил 1<br>Эрэгтэй ажилтны дундаж наслалтын судалгааг гаргах, нөлөөллийн хүчин зүйлсийг илрүүлэх ажлыг зохион байгуулна.</td><td>Хэрэгжүүлсэн байгууллага</td><td>-</td><td>тоо</td><td>-</td><td>15</td><td>Салбарын байгууллагууд</td><td>ЭХЯ</td></tr>
<tr><td colspan="9">2.2.13 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд<br>Ажилтны ажил-ар гэрийн амьдралын тэнцвэр хангасан орчин нөхцөл бүрдүүлэх стратеги, хүүхэд хамгааллын бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.</td></tr>
<tr><td>1.</td><td>Хэрэгжүүлэх ажил 1<br>“ЦДҮС” ТӨХК компанийн “Аз жаргалын өргөө” буюу хүүхдийн өрөө гаргаж тохижуулсан сайн туршлагыг судлах, олон нийтэд сурталчлана.</td><td>Хэрэгжүүлсэн байгууллага</td><td>-</td><td>тоо</td><td>-</td><td>15</td><td>Салбарын байгууллагууд</td><td>ЭХЯ</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2.2.14 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд** Жирэмсэн, хөхүүл, бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтанд уян хатан ажлын цагаар болон зайнаас ажиллах боломж бүрдүүлэх талаар Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах сайн туршлага нэвтрүүлнэ. | | | | | | | | |
| 1. | **Хэрэгжүүлэх ажил 1** Жирэмсэн, хөхүүл, бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтанд уян хатан ажлын цагаар болон зайнаас ажиллах боломж бүрдүүлэх талаар Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хөдөлмөрийн дотоод журамдаа тусгуулах ажлыг зохион байгуулна. | Хэрэгжүүлсэн байгууллага | - | тоо | - | 15 | Салбарын байгууллагууд | - |
| **2.2.19 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд** Өндөр насны тэтгэвэрт гарах эрхийн хэрэгжилтэд гарч буй зөрчлийг арилгах арга хэмжээг Хөдөлмөрийн тухай хууль, ЖЭТБХ тухай хуульд нийцүүлэн ААНБ-ын эрх зүйн баримт бичигт тусган, Ахмад настныг тэтгэвэрт бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ. | | | | | | | | |
| 1. | **Хэрэгжүүлэх ажил 1** Хөдөлмөрийн дотоод журамд ахмад настныг тэтгэвэрт бэлтгэх талаар хэрхэн туссан байдлыг тодорхойлох, судалгаа гаргана. | Хэрэгжүүлсэн байгууллага | - | тоо | - | 10 | Салбарын байгууллагууд | ЭХЯ |
| **Стратеги төлөвлөгөөний зорилт 2.3. Салбарт жендэрээс үүдэлтэй ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийллийг арилгах бодлого, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| **2.3.3 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд** ААНБ хөдөлмөрийн дотоод журамдаа ажлын байрны бэлгийн болон бусад дарамт, ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх механизмыг тусган нэвтрүүлнэ. | | | | | | | | |
| 1. | **Хэрэгжүүлэх ажил 1** Ажлын байрны бэлгийн болон бусад дарамт, ялгаварлан гадуурхалтын талаарх гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх механизмыг Хөдөлмөрийн дотоод журамд тусгах ажлыг зохион байгуулна. | Хэрэгжүүлсэн байгууллага | - | тоо | - | 15 | Салбарын байгууллагууд | ЭХЯ |
| **2.3.4 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд** Салбарын ААНБ бүрд ёс зүйн хороо байгуулж, мөрдөх дүрэм журмыг жендэрийн мэдрэмжтэй батлан мөрдүүлж, эрх нь зөрчигдсөн ажилтнуудыг хамгаалах тогтолцоог хөгжүүлнэ. | | | | | | | | |
| 1. | **Хэрэгжүүлэх ажил 1** Байгууллагын ёс зүйн хорооны мөрдөх дүрэм журмыг жендэрийн мэдрэмжтэй боловсруулах ажлыг зохион байгуулна. | Хэрэгжүүлсэн байгууллага | - | тоо | - | 10 | Салбарын байгууллагууд | ЭХЯ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 3. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ БУУРУУЛАХАД САЛБАРЫН ХУВЬ НЭМРИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОН ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилт 3.2. Хэрэглэгчдэд үйлчлэх бодлого, үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| **3.2.5 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд**<br>Иргэд, ААНБ-ын сэргээгдэх эрчим хүч ашиглах талаарх мэдлэг, хандлагыг сайжруулж, хэрэглээг нэмэгдүүлэхэд төрийн татвар, зээлийн болон эрх зүйн бусад бодлогоор дэмжиж, олон улсын сайн туршлагыг судлан, түгээн дэлгэрүүлнэ. | | | | | | | | |
| 1. | **Хэрэгжүүлэх ажил 1**<br>Иргэд, ААНБ-ын сэргээгдэх эрчим хүч ашиглах талаарх мэдлэг, хандлагыг сайжруулж, хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээ мэдээллийг олон нийтэд сурталчилан таниулах ажлыг зохион байгуулна. | Хэрэгжүүлсэн байгууллага | - | тоо | - | 10 | Салбарын байгууллагууд | - |
| **3.2.8 үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд**<br>Салбарын олон нийттэй харилцах, зар сурталчилгааны агуулгад жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт нэвтрүүлж, иргэдийн оролцооны механизм бий болгоно. | | | | | | | | |
| 1. | **Хэрэгжүүлэх ажил 1**<br>Байгууллагын олон нийттэй харилцах алба, хэвлэл мэдээллийн ажилтнуудад жендэрийн мэдрэмжтэй ажиллах анхан шатны сургалт зохион байгуулна. | Хэрэгжүүлсэн байгууллага | - | тоо | - | 10 | Салбарын байгууллагууд | - |

Танилцсан:

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга П.Билгүүн

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Г.Энхтүвшин

Эрчим хүчний үйлдвэрлэлийн ашиглалт, эрсдэлийн удирдлага, аюулгүй ажиллагааны газрын дарга Д.Батзориг

Хяналт- шинжилгээ үнэлгээ,дотоод аудитын газрын дарга Х.Бекболат

Санхүү,хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт

Нэгтгэн боловсруулсан:

Жендэрийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Б.Шүр-Эрдэнэ